



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 6 сарын 22 одор

Дугаар 134

Улаанбаатар хот

Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг "Хороо нь Улсын срөнхий байцаагч, Улсын ахлах байцаагч, Улсын байцаагчтай байх бөгөөд Хорооны дарга Улсын срөнхий байцаагч, Хорооны гишүүн, Ажлын албаны дарга, холбогдох газрын дарга Улсын ахлах байцаагч, шаардлагатай тохиолдолд хяналт шалгалтын чиг үүрэг гүйцэтгэх Хорооны ажлын албаны удирдах болон гүйцэтгэх ажилтнуудад Улсын срөнхий байцаагчийн шийдвэрээр улсын байцаагчийн эрх олгож болно." гэж өөрчлөн найруулсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-ид даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

